

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УС АШИГЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БАТСАЙХАН ОВОГТОЙ ЭНХСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. Гадаргын усны нөөцийг хомстохоос сэргийлэх, нөхөн сэргээх, арвижуулах, гадаргын ус хуримтлуулах төслийг төлөвлөн, хэрэгжүүлэх, хууль эрхзүй, үнэ тарифын орчныг сайжруулах.							
1	Арга хэмжээ 1.1.“Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт орших Эрээн нуурыг сэргээх” төслийн гүйцэтгэлд хяналт.	Хяналтын тоо-2	Ажлын гүйцэтгэл 80 хувь.	Ажлын гүйцэтгэл 90 хувь	Усны барилга байгууламж барьж буй газарт халиа маш ихээр үүсч, усанд автсан байсан тул гэрээт ажлыг газар дээр нь үргэлжүүлэх хугацаа хойшлогдсон. “Эрээн нуурыг сэргээх” ажлын урсац тохируулах, халиах барилгын туршилт тохируулгын ажил 06 дугаар сарын 15-аас эхлэхээр хүлээгдэж байна.	04 – 06	80
2	Арга хэмжээ 1.2.Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд баруун бүсийн гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах төсөл хэрэгжүүлнэ	Хөв цөөрөм байгуулах ажил гүйцэтгэх гэрээний тоо	-	Хөв цөөрөм байгуулах ажлын даалгавар боловсруулж батлуулах	Улсын төсвийн хөрөнгөөр Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймгийн гадаргын ус хомсдолтой 38 суманд байгуулах хөв цөөрмийн ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. 2025 оны 05 сарын 30-ны өдрийн байдлаар Ховд аймгийн Дөргөн суманд байгуулах хөвийн ажлыг гүйцэтгүүлэхээр “ССТ ОД” ХХК, мөн Дарви сумын Хөвхөрийн голыг түшиглэн байгуулах Булган нуур хэмээх хөвийг байгуулахаар “Эко буянт” ХХК, Завхан аймгийн Сонгино сумын “Тал булаг”-ийн хөв цөөрөм, мөн Шилүүстэй	02	100

					сумын нутагт бага оврын хөв цөөрөм байгуулах ажлыг гүйцэтгүүлэхээр “Манант Оргил” ХХК тус тус гэрээ байгуулсан.		
Зорилт 2. Ус ашиглалт болон түүний төлбөрийн мэдээллийг нэгдсэн удирдлагаар хангах.							
3	Арга хэмжээ 2.1.Хоногт 100 шоометрээс их ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд ус ашиглуулах дүгнэлтийг боловсруулж, гаргасан байх.	Ирүүлсэн хүсэлтийн дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлсэн ажлын хэрэгжилтийн хувь	-	Ирүүлсэн хүсэлтийн шийдвэр лэсэн байна.	Уул уурхай, барилга, барилгын материал үйлдвэрлэл, газрын тос олборлолт зэрэг нийт 40 аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг боловсруулж, хэлтсийн даргаар хянуулан, батлуулж хүргүүлсэн байна. Энэ нь ус ашиглалтын хэлтсийн шийдэрлэсэн хүсэлтийн 22.5 хувийг эзэлж байна.	01 – 06	100
4	Арга хэмжээ 2.2.Аймаг, нийслэлийн БОГ-ын ус ашиглалтын мэдээллийг нэгтгэж, тайлагнах.	21 аймгийн ус ашиглалтын мэдээг нэгтгэж тайлагнасан ажлын хэрэгжилтийн хувь	-	Мэдээллийг нэгтгэн холбогдох хүмүүст танилцуулна	Аймаг, нийслэлийн Байгаль орчны газраас гаргасан ус ашиглуулах дүгнэлтийг хүлээн авч нэгтгэн, мэдээллийг нэгтгэж байна. 29 сав газрын захиргаад болон 21 аймаг, нийслэлийн БОГ-аас 2025 оны эхний хагас жилд гаргасан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавин, зөвлөгөө өгч ажилласан. СГЗ-ын ногдуулсан усны хэмжээ: 1,145,500.0 м3/жил, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр: 305.7 сая төгрөг, БОАЖГ-ын ногдуулсан усны хэмжээ: 351,172.36 м3/жил, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр: 50.8 сая.төгрөг.	01 – 05	90
5	Арга хэмжээ 2.3.Уул уурхайн үйлдвэрлэлтийн ус ашиглалтын дүгнэлтийг нэгтгэх, тайлагнах.	Уул уурхайн үйлдвэрлэлийн ус ашиглалтын дүгнэлтийг нэгтгэж тайлагнасан ажлын хэрэгжилтийн хувь	-	Тоон мэдээллийг нэгтгэх	Уул уурхайн үйлдвэрлэлийн ус ашиглалтын тоон мэдээллийн холбогдох байгууллагуудаас хүлээн авч нэгтгэж байна.	01 – 06	100

Зорилт 3. Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчилах, салбарын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэн хөрш орнуудтай байгуулсан “Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай” хэлэлцээрийг хэрэгжүүлэх.

6	Арга хэмжээ 3.1.Дэлхийн усны өдрийг зохион байгуулах бэлтгэл ажилд оролцож, хариуцсан ажлыг бүрэн хэрэгжүүлэх.	Хариуцсан ажлын хэрэгжилтийн хувь.	-	“Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан хариуцсан ажлаа зохион байгуулах	Дэлхийн усны өдрийг угтан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Цэнхэр алт” үндэсний чуулганыг “Мөстэл, мөсөн голоо хамгаалъя” уриан дор зохион байгуулсан. Уг өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан илтгэгч нартай холбогдож, илтгэл, танилцуулгыг нэгтгэх болон бусад хариуцсан ажлын бэлтгэлийг бүрэн хангаж “Усны нөөцийн нэгдсэн менежмент, талуудын оролцоо” форумд оролцсон.	01 – 04	100
7	Арга хэмжээ 3.2.Ус ашиглагчдад усны талаар баримталж буй бодлого, дүрэм, журмыг танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авахаар хандсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болгонд үйлчилгээ үзүүлэх.	Мэргэжил арга зүйн зөвлөгөө авахаар хандсан иргэн, ААН, байгууллагад үзүүлсэн үйлчилгээ ний тоогоор.	-	Иргэн, ААН, байгууллагыг мэдээллээр хангах	Мэдээлэл авахаар хандсан иргэн, ААН, байгууллагыг мэдээллээр хангах	01 – 06	100

Зорилт 4. Өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах.

8	Арга хэмжээ 4.1.Албан бичиг төлөвлөх, санал бэлтгэх, хариу өгөх.	Чанар биелэлтийн байдал	-	Өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг тухай бүр шийдвэрлэх	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 14 албан бичгийг хүлээн авч, үүнээс хариутай 8, мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хандсан 16 албан бичгийн төслийг баримт бичгийн стандартын дагуу боловсруулан хянуулж, баталгаажуулан хүрүүлсэн.	01-06	100
9	Арга хэмжээ 4.2.Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу томилолтоор болон ажлын хэсэгт орж ажиллах.	Чанар биелэлтийн байдал	-	Өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж, газрын 3, нийслэлийн 3 үнэлгээний хороонд тус тус ажиллаж байна.	Удирдлагаудаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж, газрын 3, нийслэлийн 3 үнэлгээний хороонд тус тус ажиллаж байна.	01-06	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Албан томилолтоор ажилласан тухай мэдээлэл	Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд ажиллах	-	Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд ажиллаж, удирдлагуудад тайлагнах.	Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод 2025.05.24-26 ны өдрүүдэд Буйр-Мэнэнгийн талын сав газрын захиргааны талуудын оролцооны зөвлөлийн хуралд оролцож, www.ewater.mn цахим системээр ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт хэрхэн илгээх, цахим дүгнэлтийг хэрхэн боловсруулах талаар мэдээлэл хийж, сав газрын захиргааны мэргэжилтнүүд, ус ашиглагч компаниудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.	01 – 06	100
2.	Үүрэг даалгавар 2. “Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж удалдан авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.	Хуулийн хүрээнд зохион байгуулах	-	Шаардлагад нийцсэн бараа, бүтээгдэхүүн, программыг судалгааны багт хүлээлгэн өгнө.	Усны газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/76 дугаар тушаалаар “Эгийн голын усан цахилгаан станц төслийн Сэлэнгэ мөрний сав газрын экосистемд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд зориулж багаж, тоног төхөөрөмж, программ хангамж удалдан авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Уг үнэлгээний хорооны гишүүд тендерийн баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг www.tender.gov.mn цахим системд 2025.05.30-ны өдөр байршуулж, тендерийг хүлээн авч байна. Тендерийн нээлтийг 2025.06.23-ны өдөр хийнэ.	08 – 12	80

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7

1	Арга хэмжээ 1. Агентлаг болон холбогдох төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохиогдсон сургалт, семинарт хамрагдах	Сургалт, семинарт хамрагдсан байна.	-	Сургалт, семинарт хамрагдсан байна.	Төрийн албаны зөвлөл болон бусад газраас зохион байгуулсан онлайн 5, танхимаар зохион байгуулсан 12 сургалтад хамрагдаж, сургалтаас авсан мэдээ мэдээллийг өдөр тутмын ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	01 – 06	100
2	Арга хэмжээ 2. “Монгол бичиг”-ийн сургалтад хамрагдаж, албан бичгийг стандартын дагуу боловсруулна.		-	Албан бичгийг стандартын дагуу боловсруулах	Сургалт зохион байгуулагдаагүй.	01 – 06	100 <i>O</i>
3	Арга хэмжээ 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх “Суурь мэдлэг олгох” сургалтад хамрагдана.	Шинэчилсэн хуулийн сургалтад хамрагдах	A3 гэрчил гээтэй	A3 гэрчилгээгээ сунгах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай шинэчилсэн хуулийн 2 өдрийн сургалтад хамрагдаж, 2025 онд 6 үнэлгээний хороонд ажиллаж байна.	01-06	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН УС АШИГЛАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

..... Б.ЭНХСҮРЭН

2025.05.30